ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/231/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг:Naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: С.Нацагдорж<br>Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ<br>Утас: 261885 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 4**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 13

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 16**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 16

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 16

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 17

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 17

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 19

**4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 22**

4.1 Ерөнхий зүйл ........ 22

4.2 Материаллаг байдал ........ 22

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 22

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 23

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 27**

5.1 Албан шаардлага ........ 27

5.2 Зөвлөмж ........ 28

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 29**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУДШ | Монгол Улсын дээд шүүх |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НТШ | Нээлттэй тендер шалгаруулалт |
| САГ | Санхүүгийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/352

танай ______________-ны №______________-т

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.ЗАЯАДЭЛГЭР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 566 дугаар тогтоолоор 13,430,765.6 мянган төгрөгийн өртөгтэй 10582 м.кв талбай бүхий Хангарди ордны барилга, 19,072.8 мянган төгрөгөөр үнэлсэн газар эзэмших эрхийн хамт Нийслэлийн өмчөөс Монгол Улсын дээд шүүхэд ажлын байрны зориулалтаар шилжүүлсэн байна.

Хангарди ордны их засварт 8,777,393.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас их засварын ажилд 7,984,598.8 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 549,993.8 мянган төгрөг, балансаас балансад шилжиж ирсэн зураг төсвийн 308,339.7 мянган төгрөг нийт 8,842,932.3 мянган төгрөгөөр капиталжуулж, тайлант онд барилгын өртгийг 22,273,698.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,



1526140710

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тухай" 188 дугаар тогтоолоор Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дансанд бүртгэлтэй 1,400,170.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй үл хөдлөх хөрөнгийг Шүүхийн сахилгын хороонд шилжүүлэхээр даалгасан боловч тайлант онд тус барилгыг балансаас балансад шилжүүлээгүй байсныг аудитын явцад залруулсан.

**Бусад асуудлын хэсэг**

Тус газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөгөөр)*

| ДАНСНЫ КОД | Дансны нэр, төрөл | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **18,535,783,853.86** | **982,290,621.13** |
| **31** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **8,099,819,672.90** | **255,915,264.20** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 8,099,819,672.90 | 255,915,264.20 |
| 31210 | Төгрөг | 8,099,819,672.90 | 255,915,264.20 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 8,099,814,095.90 | 255,915,264.20 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 5,577.00 | - |
| **33** | **АВЛАГА** | **-** | **112,337,390.14** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 112,313,630.00 |
| 33500 | Бусад авлага | - | 23,760.14 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **2,022,611,363.00** | **55,094,630.14** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 2,022,611,363.00 | 55,094,630.14 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **472,757,097.96** | **558,943,336.65** |
| **35400** | **Хангамжийн материал** | **472,757,097.96** | **558,943,336.65** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 110,728,734.00 | 74,162,998.75 |
| 35420 | Аж ахуйн материал | 190,306,275.00 | 330,907,883.14 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,084,008.00 | 12,931,282.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 163,638,080.96 | 140,941,172.76 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **7,940,595,720.00** | **-** |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 7,940,595,720.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **19,507,442,806.43** | **32,825,564,295.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **19,507,442,806.43** | **32,825,564,295.94** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **19,070,214,223.19** | **31,910,187,490.94** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 17,653,329,000.00 | 25,315,967,218.17 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,429,107,690.08) | (1,562,154,298.44) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,673,871,792.00 | 1,882,901,192.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,342,236,965.13) | (133,258,160.89) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 3,301,299,656.87 | 5,033,511,208.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,223,286,863.53) | (1,288,728,857.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 832,491,674.01 | 2,845,739,805.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (399,227,728.12) | (366,263,287.21) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 23,880,481.89 | 186,305,747.99 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (20,799,134.72) | (3,833,077.29) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **437,228,583.24** | **915,376,805.00** |
| 39301 | Программ хангамж | 182,445,000.00 | 751,595,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (101,059,941.21) | (182,186,319.45) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 355,843,524.45 | 345,967,624.45 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **38,043,226,660.29** | **33,807,854,917.07** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **8,025,396,468.90** | **829,392,685.45** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **8,025,396,468.90** | **829,392,685.45** |
| **41300** | **Өглөг** | **8,025,396,468.90** | **829,392,685.45** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 26,437,990.31 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 8,025,396,468.90 | 800,954,695.14 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 2,000,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **30,017,830,191.39** | **32,978,462,231.62** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **30,017,830,191.39** | **32,978,462,231.62** |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 1,428,220,111.03 | 1,428,220,111.03 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **27,031,765,749.02** | **30,539,298,368.35** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,691,577,365.56 | 27,578,709,310.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 23,340,188,383.46 | 2,960,589,058.19 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,557,844,331.34 | 1,010,943,752.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН** | **38,043,226,660.29** | **33,807,854,917.07** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | | |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **37,975,741,197.23** | **23,771,178,902.42** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,992,545,279.84** | **23,771,178,902.42** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **12,992,545,279.84** | **1,803,577,969.38** |
| 120003 | Торгуулийн орлого | - | 73,907,705.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 198,803,270.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 198,803,270.00 | - |
| 120009 | Бусад орлого | 1,257,010.00 | 1,138,840,593.78 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 12,764,601,669.84 | 590,829,670.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 27,883,330.00 | - |
| 122 | Тусламжийн орлого | - | 21,967,600,933.04 |
| 1221 | Хандив тусламж/дотоод/ | - | 21,912,087,633.04 |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 21,912,087,633.04 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 18,009,555,741.44 |
| 122112 | Хөрөнгийн санхүүжилтийн орлого | - | 3,902,531,891.60 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 55,513,300.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 55,513,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **24,983,195,917.39** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **24,918,620,965.39** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 13,948,707,160.00 | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 10,969,913,805.39 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 64,574,952.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 64,574,952.00 | - |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **14,602,761,965.11** | **19,223,908,803.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,602,761,965.11** | **19,223,908,803.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **13,372,658,075.37** | **18,368,700,277.20** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **9,349,398,890.85** | **12,535,833,804.55** |
| 210101 | Үндсэн цалин | 5,627,792,960.30 | 7,472,028,903.71 |
| 210102 | Нэмэгдэл | 1,914,533,859.81 | 2,672,237,676.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 989,012,870.26 | 1,247,954,624.86 |
| 210104 | Урамшуулал | 818,059,200.48 | 1,143,612,599.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,169,475,495.77** | **1,557,112,333.25** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 795,586,784.14 | 1,059,852,082.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 93,535,245.26 | 124,717,647.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 46,951,886.70 | 62,179,964.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 46,638,535.93 | 61,826,628.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 186,763,043.74 | 248,536,010.23 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **201,393,420.35** | **349,790,630.05** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 95,393,800.08 | 198,289,203.64 |
| 210302 | Түлш, халаалт | 57,463,959.27 | 97,103,070.41 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,859,261.00 | 19,891,091.00 |
| 210304 | Байрны түрээс | 33,676,400.00 | 34,507,265.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **633,806,176.92** | **695,765,041.71** |
| 210401 | Бичиг хэрэг | 197,062,257.41 | 143,568,465.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 66,233,567.00 | 60,350,726.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 74,861,080.08 | 117,995,357.61 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,794,150.00 | 22,047,621.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 19,223,100.00 | 7,441,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 270,632,022.43 | 344,361,471.50 |
| **2105** | **Нормативт зардал** | **10,580,000.00** | **1,340,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,580,000.00 | 1,340,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **197,725,709.86** | **305,299,751.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,612,300.00 | 77,336,243.80 |
| 210602 | Тавилга | 596,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,363,000.00 | 5,528,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 173,154,409.86 | 222,435,007.20 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **427,741,804.45** | **381,810,191.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 374,315,424.45 | 354,854,191.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 42,861,150.00 | 11,610,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 10,565,230.00 | 15,346,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **228,914,008.77** | **285,424,826.51** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 102,409,127.00 | 113,837,774.37 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 66,038,489.45 | 52,766,176.49 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,650,549.00 | 8,221,578.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 50,233,247.32 | 102,205,150.65 |
| 210807 | Газрын төлбөр | 7,582,596.00 | 8,394,147.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,153,622,568.40** | **2,256,323,699.13** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,776,600.00 | 3,920,316.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 247,311,127.00 | 320,767,865.66 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 899,534,841.40 | 1,931,635,517.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,230,103,889.74** | **855,208,526.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **644,425,976.56** | **817,572,562.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 302,503,966.56 | 769,872,562.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 341,922,010.00 | 47,700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **585,677,913.18** | **37,635,964.16** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 572,047,328.18 | |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 12,379,152.00 | 37,635,621.60 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 1,251,433.00 | 342.56 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **23,372,979,232.12** | **4,547,270,099.06** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **32,790,848.66** | **1,586,681,040.87** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 32,790,848.66 | 1,586,681,040.87 |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **(32,790,848.66)** | **(1,586,681,040.87)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **23,340,188,383.46** | **2,960,589,058.19** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **33,009,849,396.29** | **22,007,429,748.04** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,026,653,478.90** | **39,828,815.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 8,026,653,478.90 | 39,828,815.00 |
| 120009 | Бусад орлого | 8,026,653,478.90 | 39,828,815.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 21,967,600,933.04 |
| 1221 | Хандив тусламж/дотоод/ | - | 21,967,600,933.04 |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 18,009,555,741.44 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 18,009,555,741.44 |
| 122112 | Хөрөнгийн санхүүжилтийн орлого | - | 3,902,531,891.60 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 55,513,300.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 55,513,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **24,983,195,917.39** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **24,918,620,965.39** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 13,948,707,160.00 | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 10,969,913,805.39 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **64,574,952.00** | **-** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 64,574,952.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **13,638,289,282.00** | **17,298,092,105.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **13,638,289,282.00** | **17,298,092,105.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,408,185,392.26** | **16,332,569,949.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **9,349,398,890.85** | **12,509,395,814.24** |
| 210101 | Үндсэн цалин | 5,627,792,960.30 | 7,471,898,587.81 |
| 210102 | Нэмэгдэл | 1,914,533,859.81 | 2,667,683,678.44 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 989,012,870.26 | 1,247,954,624.86 |
| 210104 | Урамшуулал | 818,059,200.48 | 1,121,858,923.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,169,475,495.77** | **1,557,136,093.39** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 795,586,784.14 | 1,059,875,842.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 93,535,245.26 | 124,717,647.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 46,951,886.70 | 62,179,964.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 46,638,535.93 | 61,826,628.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 186,763,043.74 | 248,536,010.23 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **201,393,420.35** | **349,724,630.05** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 95,393,800.08 | 196,895,855.64 |
| 210302 | Түлш, халаалт | 56,512,414.27 | 96,211,935.41 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,859,261.00 | 21,218,439.00 |
| 210304 | Байрны түрээс | 34,627,945.00 | 35,398,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **429,637,558.58** | **727,783,098.88** |
| 210401 | Бичиг хэрэг | 101,084,768.50 | 114,233,750.35 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 56,850,000.00 | 60,100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 75,958,580.08 | 95,634,910.23 |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 27,576,489.00 | 33,638,369.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 19,223,100.00 | 7,441,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 148,944,621.00 | 416,734,669.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **10,580,000.00** | **1,340,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,580,000.00 | 1,340,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **221,247,816.94** | **183,978,151.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,854,670.00 | 42,104,503.80 |
| 210602 | Тавилга | 596,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,363,000.00 | 5,829,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 187,434,146.94 | 136,044,147.20 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **462,799,564.45** | **353,744,688.50** |
| 210701 | Гадаад албан томилолт | 374,315,424.45 | 316,410,688.50 |
| 210702 | Дотоод албан томилолт | 53,006,380.00 | 17,388,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 35,477,760.00 | 19,946,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **291,433,719.32** | **251,238,741.65** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,119,327.00 | 85,648,997.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,585,000.00 | 64,344,069.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,650,549.00 | 8,817,578.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 111,496,247.32 | 84,033,950.65 |
| 210807 | Газрын төлбөр | 7,582,596.00 | 8,394,147.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **272,218,926.00** | **398,228,731.57** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,888,600.00 | 4,686,316.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 260,330,326.00 | 393,542,415.54 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,230,103,889.74** | **965,522,156.16** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 149,949,594.16 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 149,949,594.16 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 149,949,594.16 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 342.56 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал | - | 37,635,621.60 |
| 2131125 | Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 112,313,630.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **644,425,976.56** | **815,572,562.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 302,503,966.56 | 769,872,562.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 341,922,010.00 | 45,700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **585,677,913.18** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 572,047,328.18 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 12,379,152.00 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 1,251,433.00 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **19,371,560,114.29** | **4,709,337,642.60** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **11,391,860,441.39** | **12,553,242,051.30** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,391,860,441.39** | **12,553,242,051.30** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **11,391,860,441.39** | **12,553,242,051.30** |
| 221000 | Барилга байгууламж | - | 549,710,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 221001 | Их засвар | 9,994,705,192.90 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 3,269,231,891.60 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,397,155,248.49 | 8,734,300,159.70 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(11,391,860,441.39)** | **(12,553,242,051.30)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **7,979,699,672.90** | **(7,843,904,408.70)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 120,120,000.00 | 8,099,819,672.90 |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **8,099,819,672.90** | **255,915,264.20** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,428,220,111.03** | **1,651,828,161.34** | **3,597,593,535.56** | **6,677,641,807.93** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 93,983,830.00 | 93,983,830.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,428,220,111.03 | 1,651,828,161.34 | 3,691,577,365.56 | 6,771,625,637.93 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (93,983,830.00) | - | (93,983,830.00) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 23,340,188,383.46 | 23,340,188,383.46 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,428,220,111.03** | **1,557,844,331.34** | **27,031,765,749.02** | **30,017,830,191.39** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 546,943,561.14 | 546,943,561.14 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,428,220,111.03 | 1,557,844,331.34 | 27,578,709,310.16 | 30,564,773,752.53 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (546,900,579.10) | - | (546,900,579.10) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,960,589,058.19 | 2,960,589,058.19 |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,428,220,111.03** | **1,010,943,752.24** | **30,539,298,368.35** | **32,978,462,231.62** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **23,949,280,300.00** | **21,912,087,290.48** | **2,037,193,009.52** | **91.5** |
| 12 | Татварын бус орлого | 23,949,280,300.00 | 21,912,087,290.48 | 2,037,193,009.52 | 91.5 |
| 122 | Тусламжийн орлого | 23,949,280,300.00 | 21,912,087,290.48 | 2,037,193,009.52 | 91.5 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 23,949,280,300.00 | 21,912,087,290.48 | 2,037,193,009.52 | 91.5 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **23,949,280,300.00** | **21,828,497,290.48** | **2,120,783,009.52** | **91.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **19,859,580,300.00** | **18,009,555,398.88** | **1,850,024,901.12** | **90.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **18,755,800,300.00** | **17,216,682,836.88** | **1,539,117,463.12** | **91.8** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **12,925,992,800.00** | **12,509,395,814.24** | **416,596,985.76** | **96.8** |
| 210101 | Үндсэн цалин | 7,270,681,600.00 | 7,471,898,587.81 | (201,216,987.81) | 102.8 |
| 210102 | Нэмэгдэл | 2,777,807,600.00 | 2,667,683,678.44 | 110,123,921.56 | 96.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,626,017,700.00 | 1,247,954,624.86 | 378,063,075.14 | 76.7 |
| 210104 | Урамшуулал | 1,251,485,900.00 | 1,121,858,923.13 | 129,626,976.87 | 89.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,613,689,300.00** | **1,557,136,093.39** | **56,553,206.61** | **96.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,100,310,800.00 | 1,059,875,842.61 | 40,434,957.39 | 96.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 126,546,700.00 | 124,717,647.75 | 1,829,052.25 | 98.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 64,711,900.00 | 62,179,964.55 | 2,531,935.45 | 96.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 63,259,400.00 | 61,826,628.25 | 1,432,771.75 | 97.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 258,860,500.00 | 248,536,010.23 | 10,324,489.77 | 96.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **513,974,900.00** | **331,846,951.65** | **182,127,948.35** | **64.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 273,187,300.00 | 196,895,855.64 | 76,291,444.36 | 72.1 |
| 210302 | Түлш, халаалт | 142,067,600.00 | 91,606,657.01 | 50,460,942.99 | 64.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 53,562,700.00 | 21,218,439.00 | 32,344,261.00 | 39.6 |
| 210304 | Байрны түрээс | 45,157,300.00 | 22,126,000.00 | 23,031,300.00 | 49.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **900,754,200.00** | **731,322,813.88** | **169,431,386.12** | **81.2** |
| 210401 | Бичиг хэрэг | 200,252,200.00 | 114,233,750.35 | 86,018,449.65 | 57.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 78,944,000.00 | 60,100,000.00 | 18,844,000.00 | 76.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 116,826,300.00 | 95,634,910.23 | 21,191,389.77 | 81.9 |
| 210404 | Ном, хэвлэл | 54,827,000.00 | 33,638,369.30 | 21,188,630.70 | 61.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 32,321,800.00 | 7,441,400.00 | 24,880,400.00 | 23.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 417,582,900.00 | 420,274,384.00 | (2,691,484.00) | 100.6 |
| **2105** | **Нормативт зардал** | **17,182,700.00** | **1,340,000.00** | **15,842,700.00** | **7.8** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 17,182,700.00 | 1,340,000.00 | 15,842,700.00 | 7.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,582,909,600.00** | **1,101,557,876.00** | **481,351,724.00** | **69.6** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 695,264,400.00 | 413,205,328.80 | 282,059,071.20 | 59.4 |
| 210602 | Тавилга | 295,000,000.00 | 162,301,100.00 | 132,698,900.00 | 55.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 19,707,100.00 | 5,829,500.00 | 13,877,600.00 | 29.6 |
| 210604 | Урсгал засвар | 572,938,100.00 | 520,221,947.20 | 52,716,152.80 | 90.8 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **416,128,500.00** | **353,744,688.50** | **62,383,811.50** | **85.0** |
| 210701 | Гадаад албан томилолт | 319,054,800.00 | 316,410,688.50 | 2,644,111.50 | 99.2 |
| 210702 | Дотоод албан томилолт | 71,733,900.00 | 17,388,000.00 | 54,345,900.00 | 24.2 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 25,339,800.00 | 19,946,000.00 | 5,393,800.00 | 78.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **372,331,700.00** | **232,115,444.65** | **140,216,255.35** | **62.3** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150,000,000.00 | 62,655,000.00 | 87,345,000.00 | 41.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 69,322,600.00 | 64,344,069.00 | 4,978,531.00 | 92.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 11,642,200.00 | 8,817,578.00 | 2,824,622.00 | 75.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 118,160,100.00 | 87,904,650.65 | 30,255,449.35 | 74.4 |
| 210807 | Газрын төлбөр | 23,206,800.00 | 8,394,147.00 | 14,812,653.00 | 36.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **412,836,600.00** | **398,223,154.57** | **14,613,445.43** | **96.5** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,281,000.00 | 4,680,739.03 | 14,600,260.97 | 24.3 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 393,555,600.00 | 393,542,415.54 | 13,184.46 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,103,780,000.00** | **792,872,562.00** | **310,907,438.00** | **71.8** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,103,780,000.00** | **792,872,562.00** | **310,907,438.00** | **71.8** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 845,280,000.00 | 769,872,562.00 | 75,407,438.00 | 91.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 258,500,000.00 | 23,000,000.00 | 235,500,000.00 | 8.9 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,089,700,000.00** | **3,818,941,891.60** | **270,758,108.40** | **93.4** |
| 220001 | Барилга, байгууламж | 561,800,000.00 | 549,710,000.00 | 12,090,000.00 | 97.8 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 3,527,900,000.00 | 3,269,231,891.60 | 258,668,108.40 | 92.7 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 8,099,819,672.90 | (8,099,819,672.90) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 255,915,264.20 | (255,915,264.20) | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **202** | **170** | **32** | **84.2** |
| 620001 | Удирдах ажилтан | 10 | 10 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 152 | 120 | 32 | 78.9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 40 | 40 | - | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **202** | **170** | **32** | **84.2** |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 100 | 71 | 29 | 71.0 |
| 650004 | Ажлын албаны албан хаагч (ТҮ) | 77 | 77 | - | 100.0 |
| 650012 | Шүүгч, прокурор | 25 | 22 | 3 | 88.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **-** | **55,513,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **55,513,300.00** |
| 122 | Тусламжийн орлого | - | 55,513,300.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 55,513,300.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 55,513,300.00 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 55,513,300.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **17,877,678.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **17,877,678.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **17,877,678.40** |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 17,877,678.40 |
| 210302 | Түлш, халаалт | - | 4,605,278.40 |
| 210304 | Байрны түрээс | - | 13,272,400.00 |
| **4** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-** | **37,635,621.60** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог Монгол Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталж, эрхэм зорилгыг "Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх явдал" гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1-д Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;
- Шүүхийн хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавих;
- Шүүхэд ирүүлсэн хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг авах;
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны тоон мэдээлэл гаргах;
- Иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэг бүхий Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль.
- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн "Томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай" 133 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 224 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";

- Сангийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголттой болсон бөгөөд дотоод аудитын үйл ажиллагааг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэмд заасан чиг үүрэг, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 95 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу тус байгууллагын дотоод аудитор тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн бөгөөд дотоод аудитаар хийсэн ажлын тайлан, илрүүлэлт болон дүгнэлт, зөвлөмжөөс харахад дотоод хяналт үр дүнтэй болсон гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 87 дугаар захирамжаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд шинэчлэн боловсруулж, Монгол Улсын дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 87 дугаар захирамжаар баталсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,235,371.8 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 8,099,819.7 | 255,915.3 | (7,843,904.4) |
| Авлага | - | 112,337.4 | 112,337.4 |
| Урьдчилгаа | 2,022,611.4 | 55,094.6 | (1,967,516.8) |
| Бараа материал | 472,757.1 | 558,943.3 | 86,186.2 |
| Үндсэн хөрөнгө | 19,507,442.8 | 32,825,564.3 | 13,318,121.5 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 7,940,595.7 | - | (7,940,595.7) |
| **Нийт хөрөнгө** | **38,043,226.7** | **33,807,854.9** | **(4,235,371.8)** |
| Өр төлбөр | 8,025,396.5 | 829,392.7 | (7,196,003.8) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 30,017,830.2 | 32,978,462.2 | 2,960,632.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **38,043,226.7** | **33,807,854.9** | **(4,235,371.8)** |

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 255,915.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,843,904.4 мянган төгрөгөөр буурсан нь он дамжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг тайлант онд шилжүүлсэнтэй холбоотой байна. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд чанарын баталгааны барьцааны 250,124.7 мянган төгрөг, техник хяналтын зардлын 5,790.5 мянган төгрөг байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 112,337.4 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын данснаас 83,590.0 мянган төгрөг, ахмадын сангийн дансны үлдэгдэл 28,723.6 мянган төгрөгийг төвлөрүүлснээс үүссэн татаас санхүүжилтийн авлага болон Нийгмийн даатгалаас авах 23.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна.
- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өмнөх оноос 1,967,516.8 мянган төгрөгөөр буурч 55,094.6 мянган төгрөг болсон нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний үлдэгдэл төлбөрийг төлж, үндсэн хөрөнгөд бүртгэснээс шалтгаалсан байна.

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 13,318,121.5 мянган төгрөгөөр өссөн бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:
    - Өссөн шалтгаан: Байгууллагын барилгын их засварын гүйцэтгэлтэй холбоотой 7,940,595.7 мянган төгрөгөөр, өмнөх онд урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэгдсэн хөрөнгийн гүйцэтгэлийг үндсэн хөрөнгөд шилжүүлсэн бүртгэснээс 2,127,905.6 мянган төгрөгөөр, улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,934,680.0 мянган төгрөгөөр, урсгал санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө 1,100,888.3 мянган төгрөгөөр, балансаас балансад шилжиж ирсэн хөрөнгө 308,339.67 мянган төгрөгөөр, үнэ шинэчлэн тогтоосонтой холбоотой 1,307,492.2 мянган төгрөгөөр, хандив тусламжийн орлого 72,490.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.
    - Буурсан шалтгаан: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу 283,040.9 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг

акталж, мөн бусад шүүхийн байгууллагуудад балансаас балансад 1,866,261.6 мянган төгрөгийн хөрөнгийн тус тус шилжүүлснээс голлон нөлөөлсөн;

- Өр төлбөрийн дансны үлдэгдэл тайлант оны эцэст 829,392.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,196,003.78 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 32,978,462.2 мянган төгрөг болж 2,960,632.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 6,380.200.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 21,480,429.8 мянган төгрөг, нийт зарлагыг 27,860,629.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант оны батлагдсан төсвийг 2,149,349.5 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Төсвийн төлөвлөлтийн тухайд төсөв захирагчийн саналыг харгалзан үзэлгүйгээр батлагдсан төсвийг бууруулсан, төсвийн тодорхой хэсэгт Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавартай холбогдуулан санхүүжилтийн эрх нээгээгүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа” хөтөлбөрийн 6 арга хэмжээний хүрээнд нийт 23,949,280.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 21,912,087.3 мянган төгрөгийг зарцуулж, 0.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 8,099,819.7 мянган төгрөгөөс 7,843,904.4 мянган төгрөгийг барилгын их засварын ажилд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын 91.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,451,772.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавартай холбогдуулан Сангийн яамнаас 1,850,023.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эрх олгоогүй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| **70702** | | **Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа** | **23,949,280.3** | **21,912,087.3** | **2,037,193.0** | **91.5** |
| 1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 18,605,800.3 | 17,154,027.8 | 1,451,772.5 | 92.2 |
| 2 | 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 69,570.0 | 3,400.0 | 66,170.0 | 4.9 |
| 3 | 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 61,680.0 | 52,605.0 | 9,075.0 | 85.3 |
| 4 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 1,103,780.0 | 792,872.6 | 310,907.4 | 71.8 |
| 5 | 82321 | Шинжээч, орчуулагч хэлмэрчийн зардал | 18,750.0 | 6,650.0 | 12,100.0 | 35.5 |
| 6 | 80918 | Бусад /хөрөнгө оруулалт | 4,089,700.0 | 3,902,531.9 | 187,168.1 | 95.4 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Судалгааны үр дүн:** Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

- Цалин хөлсний зардлыг 14,178,785.8 мянган төгрөгийн төсөвтэй 264 орон тоотой байхаар баталсан бөгөөд тайлант онд төсвийг тодотгож 12,925,992.8 мянган төгрөг болгон бууруулж, орон тоог 202-оор баталсан байна. Тайлант оны гүйцэтгэлээр 32 орон тоогоор дутуу ажиллаж, гүйцэтгэлээр 170 орон тоонд 12,509,395.8 төгрөгийн цалин, хөлсний зардлыг зарцуулсан байна.
- Албан хаагчдын нийтийн тээврийн унаа, өдрийн хоолны зардлын хэмжээг Тамгын газрын даргын 2024 оны А/73 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 32.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 3.0 мянган төгрөгөөр баталсныг тайлант онд шинэчлэн тогтоогоогүй байна. Унаа, хоолны зардлын төсвийг 1,626,017.7 мянган төгрөгөөр баталснаас тайлант онд 1,247,954.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 378,063.1 мянган төгрөгөөр хэсэн байна.
- Гадаад албан томилолттой холбоотой 29 арга хэмжээнд 342,678.6 мянган төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр 33 арга хэмжээнд 322,229.8 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд аудитаар тушаал шийдвэргүй болон хууль тогтоомжид нийцээгүй асуудал гараагүй байна.
- Тайлант онд хэвлэл, мэдээллийн 3 байгууллагатай нийт 53,700.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж ажилласан байна.
- Тайлант онд төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой төсвөөс зардал гараагүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т " нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 55,513.3 мянган төгрөг төвлөрсөн байна. Үүнээс түлш халаалтын зардалд 4,605.3 мянган төгрөг, байрны түрээсийн төлбөрт 13,272.4 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 37,635.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын дээд Шүүхийн Тамгын газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, нийт 38 төсөл арга хэмжээг 6,417,233.5 мянган төгрөгийн төсөвтэйгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар шууд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй зөрчилд зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, шууд худалдан авалтуудыг тусгаснаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нийт төсөв 6,637,596.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Худалдан авах ажиллагааны тайланг 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн бөгөөд гүйцэтгэлээр 5,287,497.5 мянган төгрөгийн 20 худалдан авалтад НТШ-ын арга , 411,189.1 мянган төгрөгийн 6 худалдан авалтад харьцуулалтын арга, 101,759.8 мянган төгрөгийн 12 худалдан авалтад шууд худалдан авалтын аргыг тус тус ашиглан тайлант онд нийт 5,800,446.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаар тайлагнасан байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 05/150 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 14,635,552.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 219,533.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай зорилготой Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын зардлууд дараах материаллаг дүнгээр хэмнэгдсэн байна. Үүнд:

- Тайлант онд цалингийн санг 202 орон тоотой байхаар баталсан боловч гүйцэтгэлээр 170 орон тоотой ажиллаж цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төсвөөс 416,596.9 мянган төгрөг;
- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төсвийн хэмнэлтээс шалтгаалан нийгмийн даатгалын шимтгэл 56,553.2 мянган төгрөг;

- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 310,907.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын төсвийг 235,500.0 мянган төгрөг;
- Гэрэл цахилгаан, халаалт, дулаан ашиглалтын төсвийн төлөвлөлттэй холбоотойгоор байр ашиглалттай холбоотой зардал 182,127.9 мянган төгрөг;
- Санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс хангамж, бараа материалын зардал 169,431.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 481,351.7 сая төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал 66,170.0 мянган төгрөг;

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгаврын хэрэгжилттэй холбоотой Сангийн яамнаас нийт 1,845,017.7 мянган төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээгээгүй, санхүүжилт олгоогүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 660,680.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*<u>Илрүүлэлт:</u>* Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 110,780.6 мянган төгрөгийн 13 удаагийн зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй 549,900.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг тус тус Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.4.1-т "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.2.5-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан

авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 2.2.1.10-т "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 2.2.1.13-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох шийдвэрийн хуулбарын хамт", 3.2.14-т "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлж байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**4.4.2.1.** *Илрүүлэлт:* Тус газар нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээний ажлын даалгавар, техникийн үзүүлэлтийг ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана", 12.2-т "Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.2-т "Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, төсвийн тооцоог боловсруулж байх, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдэж байх албан шаардлага хүргүүлэв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар тайлант оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

Завсрын аудитаар тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, үндсэн хөрөнгө, цалингийн зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, томилолт, хоол унааны зардлын дансдууд болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулсан. Завсрын аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 317,112.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,337.2 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, үүнээс 16,337.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн сайжруулалт болон үндсэн хөрөнгийн хяналттай холбоотой 3 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Тайлант онд албан шаардлага бүрэн хэрэгжсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 16,337.2 | 1 | 16,337.2 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | - | 2 | - | 66.6 |
| **Нийт дүн** | **4** | **16,337.2** | **8** | **16,337.2** | **83.3** |

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуульд заасан цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 456,631.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын нийт 3,074,486.4 мянган төгрөгийн 9 гүйлгээг шилэн дансанд хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 660,680.6 мянган төгрөгийн зөрчил давтан гарсан тул санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүллээ.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэхээр зохицуулсан боловч “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем” дэх тайлангийн зарим үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байгааг цаашид анхаарах нь зүйтэй байна.

2. Тус Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Хангарди ордны барилга нь 2008 онд ашиглалтад орж 13,430,768.6 мянган төгрөгийн өртөгтэй бөгөөд одоог хүртэл анхны өртгөөр бүртгэлд тусгаж, дахин үнэлгээ хийгдээгүй байгаа нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17 Үндсэн хөрөнгө 17.49 “Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллагаар өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай, харин үнэ цэнэд ялимгүй бага өөрчлөлт ордог үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд гурав буюу таван жил тутамд дахин үнэлэх шаардлагатай” гэж заасныг хангахгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,400,170.1 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тухай" 188 дугаар тогтоолоор Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дансанд бүртгэлтэй 1,400,170.1 мянган төгрөгийн анхны өртөгтэй үл хөдлөх хөрөнгийг Шүүхийн сахилгын хороонд шилжүүлэхээр даалгасан боловч тайлант онд тус барилгыг балансаас балансад шилжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" УСНББОУС 1, УСНББОУС 19, УСНББОУС 24, УСНББОУС 31 дэх заалтуудтай тус тус нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 167,124.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд, 35,830.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 131,293.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчлөөс 167,124.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 219,533.3 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Тайлант онд 6 гэрээг үнийн дүнгүйгээр байгуулж, гүйцэтгэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу нийт 35,830.5 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.6 "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Иргэний хуулийн 344 дүгээр зүйлийн 344.1 "Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно", 344.2 "Ажил гүйцэтгэсний хөлсийг талууд тохиролцоогүй боловч гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал зэргээс шалтгаалан захиалагч тухайн төрлийн ажил гүйцэтгэхэд мөрддөг эрх бүхий байгууллагаас баталсан жишиг үнэлгээний жагсаалт байвал тухайн жагсаалтыг үндэслэн, тийм жагсаалт байхгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлс төлнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

---

*[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

*2 Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

**Шийдвэрлэсэн нь:** Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээнд үнийн дүнг заавал тусгаж, гэрээний үнийн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд 26,437.9 мянган төгрөгийн цалин, урамшууллын өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5 "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Тайлант онд төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах.

2. Барьцаа хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний барьцаа 83,590.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүйгээс жилийн эцсээр төрийн санд буцаан төвлөрүүлсэн, урсгал зардлын санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний барьцаа 21,265.8 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүйгээс тайлант оны үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой чанарын баталгааг барьцаа хөрөнгийн дансанд хуульд заасан хувь хэмжээгээр төвлөрүүлэх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тухай" 188 дугаар тогтоолоор Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дансанд бүртгэлтэй 1,400,170.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй үл хөдлөх хөрөнгийг Шүүхийн сахилгын хороонд шилжүүлэхээр даалгасан боловч тайлант онд тус барилгыг балансаас балансад шилжүүлээгүй | 1 | 1,400,170.1 | 1 | 1,400,170.1 | - | - | 1 | 1,400,170.1 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **1,400,170.1** | 1 | **1,400,170.1** | **-** | **-** | **1** | **1,400,170.1** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой 6 гэрээг үнийн дүнгүй байгуулж, гүйцэтгэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу нийт 35,830.5 төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна. | 1 | 35,830.5 | - | - | 1 | 35,830.5 | - | - | - | - | - | - |
| Тайлант онд 26,437.9 мянган төгрөгийн цалин, урамшууллын өглөг үүсгэсэн байна. | 1 | 26,437.9 | - | - | - | - | 1 | 26,437.9 | - | - | - | - |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний барьцаа 83,590.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй, жилийн эцсээр төрийн санд буцаан төвлөрүүлсэн, урсгал зардлын санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний барьцаа 21,265.8 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүйгээс тайлант оны үйл ажиллагаанд зарцуулсан байна. | 1 | 104,855.8 | - | - | - | - | 1 | 104,855.8 | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **167,124.2** | **-** | **-** | **1** | **35,830.5** | **2** | **131,293.7** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 110,780.6 мянган төгрөгийн 13 удаагийн зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй 549,900.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг тус тус Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна. | 1 | 660,680.6 | 1 | 660,680.6 | - | - |
| Дүн | **1** | **660,680.6** | **1** | **660,680.6** | **-** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээнд ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул | 1 | - | 1 | - | - | - |
| Дүн | 1 | - | 1 | - | - | - |
| **Нийт дүн** | **2** | **660,680.6** | **2** | **660,680.6** | **-** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 76/А0170433 Улаанбаатар хот

САГ-2026/231/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой 6 гэрээг үнийн дүнгүй байгуулж, гүйцэтгэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу нийт 35,830,500.00 /гучин таван сая найман зуун гучин мянга таван зуун/ төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Иргэний хуулийн 344 дүгээр зүйлийн 344.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно", 344.2-т "Ажил гүйцэтгэсний хөлсийг талууд тохиролцоогүй боловч гүйцэтгэсэн ажлын шинж, ажил гүйцэтгэх болсон нөхцөл байдал зэргээс шалтгаалан захиалагч тухайн төрлийн ажил гүйцэтгэхэд мөрддөг эрх бүхий байгууллагаас баталсан жишиг үнэлгээний жагсаалт байвал тухайн жагсаалтыг үндэслэн, тийм жагсаалт байхгүй бол тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлс төлнө" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээг үнийн дүнгүй байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга /С.Заяадэлгэр/, ахлах нягтлан бодогч /Ш.Гантуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | С.НАЦАГДОРЖ |
| АХЛАХ АУДИТОР | Э.БАТ-ЭРДЭНЭ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

9006ТС9
АТА16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-11.Docx

1526180264

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 77/А0170433 Улаанбаатар хот

САГ-2026/231/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газар нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээний ажлын даалгавар, техникийн үзүүлэлтийг ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана", 12.2-т "Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.2-т "Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг ерөнхий байдлаар боловсруулсан, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдэхгүй байгаа зөрчлүүдийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга /С.Заяадэлгэр/, ахлах нягтлан бодогч /Ш.Гантуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ

АХЛАХ АУДИТОР Э.БАТ-ЭРДЭНЭ

9006109

АТА16037

9025081411

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 78/А0170433 Улаанбаатар хот

САГ-2026/231/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 110,780,600.00 /нэг зуун арван сая долоон зуун наян мянга зургаан зуун/ төгрөгийн 13 удаагийн зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй 549,900,000.00 /таван зуун дөчин есөн сая есөн зуун мянган/ төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг тус тус Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.1-т "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.2.5-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 2.2.1.10-т "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 2.2.1.13-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох шийдвэрийн хуулбарын хамт", 3.2.14-т "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлэхгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга /С.Заяадэлгэр/, ахлах нягтлан бодогч /Ш.Гантуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР Э.БАТ-ЭРДЭНЭ

9006109
АТА16087
9025081411